



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.08.19 № 680

танай _____ ны № _____ т

**БУЛГАН АЙМГИЙН БУГАТ
СУМЫН СОНГУУЛИЙН ХОРООНД**

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн
талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Бугат сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Б.Оюунтуяагийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа,

006021369

мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч иргэн Б.Оюунтуяа Бугат сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч иргэн Б.Оюунтуяагийн мөрийн хөтөлбөр (.....хуудас)-ийг хавсаргав

Хувийг: Бие даан нэр дэвшигч иргэн Б.Оюунтуяад

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

**БУЛГАН АЙМГИЙН БУГАТ СУМЫН 2024 ОНЫ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ Д.ОЮУНТУЯАГИЙН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Нэг.Нийгмийн бодлого

1.1 Эрүүл мэндийн бодлого

- 1.1.1 Цэцэрлэг, сургуулиудын хүүхдүүдийн шүд амны хөндийг эрүүлжүүлэх мэргэжлийн эмч нарын эрүүл мэндийн үзлэгт хамруулах бодлогыг баримтлана.
- 1.1.2 Сумын хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний уст цэгийн төлөвлөлт, байршил, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах бодлогыг баримтлана.
- 1.1.3 Эрүүл мэндийн анхан шатны болон нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх, эрт илрүүлэх боломжоор багийн иргэдийг хамруулах, сурталчлах бодлогыг хэрэгжүүлнэ.

1.2 Боловсролын бодлого

- 1.2.1 Багийн гэр цэцэрлэгийн үйл ажиллагааг тогтмолжуулах, сургуулийн өмнөх боловсролын чанар хүртээмжийг байжруулах бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.2.2 Урлагийн авьяастай хүүхдүүдийн авьяааг нээн илэрүүлэх, сурталчлан таниулах бодлогыг барина.
- 1.2.3 Багийн хүүхдийн хамран сургалтыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ

1.3 Хөдөлмөр эрхлэлт талаар

- 1.3.1 Ахмадуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрт хамрагдах бодлогыг дэмжинэ.

Хоёр.Эдийн засгийн хөгжлийн бодлого

2.1 Хөдөө аж ахуйн бодлого

- 2.1.1 Малчдыг хоршооны үйл ажиллагаа эрхлэх, нөхцөл боломжийг бүрдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.1.2 Мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах , халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний бодлогыг хэрэгжүүлнэ.

2.2 Үйлдвэрлэл худалдаа үйлчилгээний бодлого

- 2.2.1 Орон нутагт хүн амын хүнсний хангамж түүний аюулгүй байдалд тавих хяналтыг бодлогоор дэмжинэ.

2.3 Дэд бүтэц

- 2.3.1 Газар зохион байгуулалтын төлөвлөлт, газар ашиглалтыг сайжруулж, газрын зөрчлийг арилгах ажлыг бодлогоор дэмжинэ.

2.4 Төсөв санхүүгийн чиглэлээр

- 2.4.1 Сумын өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт, төсөв, түүний төлөвлөлт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн гүйцэтгэлд иргэд хяналт тавих бодлогыг хэрэгжүүлнэ.

Иргэдийнхээ эрх ашгийг дээдэлсэн,
Шударга ёс ил тод, шуурхай үйлчилгээг орон нутагт төлөвшүүлнэ

МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН:

Д.Оюунтуяа

/Д.ОЮУНТУЯА/ 99359177

